



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 9/01

Хархорин сум

Цалингийн санг
шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1, 2.3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3, 10, 11, 12 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын цалингийн санг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан цалингийн санд багтаан албан хаагчдын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бодож олгохыг нягтлан бодогч (О.Гангацэрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.ЯХАГВАДУЛАМ



403100001

C:\My Doc\Тушаал\ZDTG\

Засаг даргын Тамгын газрын даргын
2026 оны 01...дүгээр сарын 22...ны өдрийн
...01...дугаар тушаалын хавсралт



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИНГИЙН САН

д/д	Овог нэр	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Албан тушаалын цалин	Төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл (хувь)	Зэрэг дэвийн нэмэгдэл /Онцгой нөхцөлийн/ (хувь)	Орон нутгийн нэмэгдэл (хувь)	Ур чадвар, зэргийн нэмэгдэл/ мэргэшсэн нягтлан бодогч (хувь)	Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл (хувь)	Хоолны хөнгөлөлт
1	Б.Бат-Эрдэнэ	Засаг дарга	УТ	2,274,000	-	30	80	-	-	15,000
2	Ц.Баатарсүрэн	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-7	1,539,000	6	20	80	-	-	15,000
3	С.Баасансүрэн	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	T3-8	1,399,000	15	18	80	25	20	15,000
4	Н.Нямдаваа	Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	T3-9	1,283,000	16	20	80	-	-	15,000
5	А.Цэрэнчимэд	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1,283,000	2	-	80	-	-	15,000
6	Ж.Солонго	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1,283,000	12	20	80	-	-	15,000
7	Э.Нарангэрэл	Соёл, аялал жуулчлал	T3-9	1,283,000	1	-	80	-	-	15,000

		хариуцсан мэргэжилтэн								
8	С.Мөнхсоёл	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1,283,000	8	20	80	-	-	15,000
9	Т.Бямбасүрэн	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1,283,000	12	20	80	-	-	15,000
10	Э.Үүрцайх	Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-7	1,539,000	3	-	80	-	-	15,000
11	Б.Пүрэвсүрэн	Багийн Зохион байгуулагч	T3-10	1,166,000	3	-	80	-	-	15,000
12	С.Мөнхзул	Багийн Зохион байгуулагч	T3-10	1,166,000	10	-	80	-	-	15,000
13	Б.Сарангэрэл	Багийн Зохион байгуулагч	T3-10	1,166,000	4	-	80	-	-	15,000
14	О.Гангаацэрэн	Нягтлан бодогч	ТҮМ-7	1,559,000	1	-	80	-	-	15,000
15	Б.Мөнхзул	Архив, бичиг хэргийн эрхлэгч	ТҮМ-3	1,283,000	8	-	80	-	-	15,000
16	Б.Должин	Угтах үйлчилгээний ажилтан	ТҮ-4	1,105,000	-	-	80	-	-	15,000
17	Н.Отгонбаяр	Нярав	ТҮ-4	1,105,000	1	-	80	-	-	15,000
18	М.Оюунбилэг	Жолооч	ТҮ-3	1,052,000	1	-	80	-	-	15,000
19	Ө.Отгонжаргал	Үйлчлэгч	ТҮ-1	954,000	3	-	80	-	-	15,000

---oOo---



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1/02

Хархорин сум

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Засгийн газрын 2026 оны "Ажил амралтын цагийн зохицуулалтын тухай" 22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн баяраар амрах амралтын өдрүүд буюу 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 02 дугаар сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд үүрэг гүйцэтгэх хариуцлагатай жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Засаг даргын Тамгын газрын болон аж ахуйн нэгжүүдийн харуул, жижүүрийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэн, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг албан хаагчид үүрэг болгосугай.

3.Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Хархорин агро, ус цаг уурын салбараас холбогдох мэдээ, мэдээллийг авч, жижүүрийн тэмдэглэл хөтөлж ажиллахыг хариуцлагатай жижүүрт даалгасугай.

ДАРГА




Х.ЛХАГВАДУЛАМ

C:\My Doc\Тушаал\ZDTG\

403100013

Засаг даргын Тамгын газрын даргын
2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
102 дугаар тушаалын хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

Д/д	Хариуцлагатай жижүүр хийх албан хаагчийн нэр	Албан тушаал	Үүрэг гүйцэтгэх хугацаа
2026 оны 02 дугаар сарын 17			
1	Б.Төгөлдөр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан	09:00-13:00
2	С.Баасансүрэн	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	13:00-18:00
3	О.Зургаан-Эрдэнэ	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан	18:00-22:00
2026 оны 02 дугаар сарын 18			
4	Н.Төгөлдөр	Байгаль хамгаалагч	09:00-13:00
5	Ц.Баатарсүрэн	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	13:00-18:00
6	С.Пунцагнамжил	Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	18:00-22:00
2026 оны 02 дугаар сарын 19			
7	Г.Лхагвабуд	Хотын захирагчийн албаны ерөнхий менежер	09:00-13:00
8	Э.Очир-Эрдэнэ	Архитектор	13:00-18:00
9	Ц.Гомбосүрэн	Багийн Засаг дарга	18:00-22:00
2026 оны 02 дугаар сарын 20			
10	Л.Төгөлдөр	Багийн Засаг дарга	09:00-13:00
11	Д.Гантөмөр	Багийн Засаг дарга	13:00-18:00
12	С.Мөнхсоёл	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	18:00-22:00
2026 оны 02 дугаар сарын 21			
13	О.Батсүх	Багийн Засаг дарга	09:00-13:00

14	М.Оюунбилэг	Жолооч	13:00-18:00
15	Ө.Энхжаргал	Багийн Засаг дарга	18:00-22:00
2026 оны 02 дугаар сарын 22			
16	Р.Сүхбат	Багийн Засаг дарга	09:00-13:00
17	Ч.Баттулга	Газрын даамал	13:00-18:00
18	Э.Үүрцайх	Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	18:00-22:00

--oOo--



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар

1/03

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын Засаг даргын 2022 оны А/151 дүгээр захирамжаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.4.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дархлааг дэмжин аарц, чацарганаар үйлчлэх зардалд 675,000 (зургаан зуун далан таван мянга) төгрөг зарцуулж, задаргааг хавсралтаар баталсугай.

2.Уг зардлыг Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



ХЛХАГВАДУЛАМ

400100005

C:\My Doc.\Тушаал\ZDTG\

Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
1/02 дугаар тушаалын хавсралт



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ДАРУУЛАГ
ДЭМЖИН ААРЦ, ЧАЦАРГАНДАР ҮЙЛЧЛЭХ ЗАРДАГ

Д/д	Зардалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Аарц	л	125	5000	675,000
ДҮН					675,000

--000--



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 2/04

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газарт ажиллаж байсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд 3,724,000 (гурван сая долоон зуун хорин дөрвөн мянга) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Х.ЛХАГВАДУЛАМ

401100007

C:\My Doc.\Тушаал\ZDTG\

Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн
10/01 дүгээр тушаалын хавсралт



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АХМАД НАСТРУУДАГ
ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЗАРДАГ

Д/д	Зардалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Гарын бэлэг	ш	38	98,000	3,724,000
ДҮН					3,724,000

--000--



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 1/05

Хархорин сум

Ээлжийн амралтын хуваарь
батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, 99.2, 99.3, 99.4 дэх заалт, 99.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2026 оны ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Ээлжийн амралтын олговрыг холбогдох журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Х.ЛХАГВАДУЛАМ



403100039

C:\My Doc\Тушаал\ZDTG\

Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
1/4 дугаар тушаалын хавсралт



**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
ЭЭЛЖИЙН АМРАЛТЫН ХУВААРЬ**

№	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Ажилласан жил	Амралтын хоног		Амралт эхлэх, дуусах хугацаа
				Үндсэн хоног	Нэмэгдэл хоног	
1	С.Баасансүрэн	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	17.5	15	7	2026.08.03-2026.09.02
2	Ц.Баатарсүрэн	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	7.2	15	3	2026.11.02-2026.11.27
3	Н.Нямдаваа	Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	16.5	15	7	2026.08.03-2026.09.02
4	Э.Үүрцайх	Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	3.10	15	-	2026.08.03-2026.08.24
5	С.Мөнхсоёл	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	8.6	15	3	2026.08.03-2026.08.27
6	Т.Бямбасүрэн	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	13	15	5	2026.08.10-2026.09.07
7	Ж.Солонго	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	22.6	15	9	2026.08.03-2026.09.11
8	А.Цэрэнчимэд	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	3	15	-	2026.03.02-2026.03.23
9	Э.Нарангэрэл	Соёл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	1.4	15	-	2026.08.03-2026.08.24
10	Б.Пүрэвсүрэн	Багийн Зохион байгуулагч	3.7	15	-	2026.08.03-2026.08.24
11	Б.Сарангэрэл	Багийн Зохион байгуулагч	4.5	15	-	2026.08.03-2026.08.24

12	Д.Хишигсүрэн	Багийн Зохион байгуулагч	23.7	20	9	2026.08.03-2026.09.11
13	О.Гангаацэрэн	Нягтлан бодогч	10	15	3	2026.08.24-2026.09.17
14	Б.Мөнхзул	Архив, бичиг хэргийн эрхлэгч	8.4	15	3	2026.08.03-2026.08.27
15	Н.Отгонбаяр	Нярав	7	15	3	2026.08.03-2026.08.27
16	Б.Должин	Угтах үйлчилгээний ажилтан	1	15	-	2026.04.01-2026.04.22
17	М.Оюунбилэг	Жолооч	1	15	-	2026.08.03-2026.08.24
18	Ө.Отгонжаргал	Үйлчлэгч	3.7	15	-	2026.08.03-2026.08.27

---oOo---



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/05

Хархорин сум

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3, 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Гишүүд: Н.Нямдаваа (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)
С.Мөнхсоёл (Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Р.Сүхбат (Багийн Засаг дарга)

2.Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын 2025 оны А/07 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Х.ЛХАГВАДУЛАМ

403100011

C:\My Doc\Тушаал\ZDTG\



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 11/07

Хархорин сум

Хүүхэд хамгааллын бодлогыг
батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хүүхэд хамгааллын бодлогыг байгууллагын үйл ажиллагааны онцлог, дотоод хэм хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлж ажиллахыг ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Цэрэнчимэд)-д даалгасугай.

ДАРГА Х.ЛХАГВАДУЛАМ



10010013

C:\My Doc\Тушаал\ZDTG\

Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн
11.07 дугаар тушаалын хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО**

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

"Хүүхэд" гэж 18 нас хүртэлх хүн бүрийг хүүхэд гэнэ.

"Хүүхдийн сайн сайхан байдал" гэж хүүхдийн бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, боловсрол, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага хангагдсан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг;

"Хүүхэд хамгаалал" гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;

"Хүүхдийн эсрэг хүчирхийлэл" /цаашид "хүчирхийлэл" гэх/ гэж хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулах, бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг;

"Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж дараах хүүхдийг ойлгоно:

1. Амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд;

2. Хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд;

3. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд;

4. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдалд байгаа хүүхэд.

"Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд" гэж дараах хүүхдийг ойлгоно:

1. Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд;

2. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;

3. Зөрчилд холбогдогч хүүхэд;

4. Зөрчил үйлдэж шийтгэгдсэн, эрүүгийн хариуцлага хүлээсэн, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд;

5. Иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд.

"Хүүхдийг үл хайхрах" гэж хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үүрэг хүлээсэн бусад этгээд хүүхдийн аюулгүй байдал, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсрол, хөгжлийн хэрэгцээг гачигдуулсан, асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсныг;

"Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхэд" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийг;

"Үе тэнгийн дээрэлхэлт" гэж нэг буюу хэд хэдэн хүүхэд өөр нэг буюу хэд хэдэн хүүхдийг бие махбод, сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой түрэмгий зан үйлээ санаатайгаар, удаа

дараа биеэр, амаар болон цахим орчинд үйлдэхийг;

"Хүүхэд хамгааллын үйлчилгээ" гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг;

"Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар шийдвэр гаргах, уг шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий орон нутгийн орон тооны бус нэгжийг;

"Хориотой агуулга" гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

"Хүүхдэд хортой агуулга" гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

ХОЁР.ҮНДСЭН ЗАРЧМУУД

2.1.Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзнэ.

2.2.Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

2.3.Аливаа үйл ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх

ГУРАВ.ХАМРАХ ХҮРЭЭ

3.1.Энэхүү бодлого нь байгууллагын үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагчид, сайн дурын ажилтан, дадлагажигч ажилтан босоо удирдлагатай албан хаагчид болон хамтран ажиллах байгууллага болон хувь хүмүүст хамаарна.

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1.Байгууллага, ажил олгогч нь ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөрийн харилцааны уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах.

4.2.Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэдтэй ажилтан, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ. Үүнд:

4.2.1.Богиносгосон цагаар ажиллах;

4.2.2.Цахимаар ажиллах;

4.2.3.Хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авах боломжоор хангах;

4.2.4.Цалингийн нэмэлт, урамшуулал дэмжлэг үзүүлэх;

4.2.5.Бусад дэмжлэгт хамруулах.

4.3.Хүүхдэд ээлтэй байгууллагын шалгуурыг салбарын хэмжээнд мөрддөг

хууль тогтоомж болон Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах.

4.4.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг", "Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж"-ийн дагуу байгууллага, аж ахуйн нэгж бүр ажилтнуудын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын нөөц, хэрэгцээнд түшиглэн зохион байгуулах "Эцэг эхийн зөвлөл" /цаашид Зөвлөл гэх/-ийг байгуулах. Үүнд:

4.4.1.Зөвлөлийн дарга төлөвлөгөөг 1 жилийн хугацаатайгаар гарган хамт олноор хэлэлцүүлж, батлах бөгөөд биелэлтийг байгууллагын удирдлага, нийт хамт олонд тайлагнах;

4.4.2.Байгууллага хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийж үр дүнд үндэслэн сайжруулж, мөрдүүлэх;

4.4.3.Байгууллагын мэдээллийн самбар цахим хуудаст байршуулж, сурталчлан таниулах;

4.4.4.Байгууллагын ажилтан, албан хаагчийн гэр бүл, хүүхдийн нөхцөл байдлын судалгаа хийж, хэрэгцээнд суурилсан сургалт, бодит дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучлах.

4.5.Байгууллага бүр албан хаагчадаа зориулж сургалт нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.5.1.Ажилтан, албан хаагчийн хүүхдийн сурч боловсрох, хөгжил, хамгааллыг дэмжих, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олон болох санаачилгыг өрнүүлж, байгууллагын удирдлагатай хамтран ажиллах;

4.5.2.Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтан, албан хаагч, тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах.

4.6.Байгууллага бүр өөрийн боломж, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн санал санаачилгыг өрнүүлж байгууллагын нөөцөд тулгуурлан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. Тухайлбал:

4.6.1.Хүүхдийн хөгжих, эрүүл аюулгүй, хараа хяналттай байхад үргэлж анхаарч, байгууллагын дэргэдэх хүүхдийн өрөө, ажилтны амрах өрөө байгуулах;

4.6.2.Байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийх, илэрсэн эрсдэлийг арилгах арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;

4.6.3.Байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

ТАВ.БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ЗААВАР

5.1.Зохион байгуулалт: Байгууллага бүр хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах (Гэр бүлийн зөвлөл) байгуулж ажиллах бөгөөд энэхүү зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, бодлогыг нийт ажилтан болон нийтэд харагдахуйц газар, байгууллага дээр болон цахим хуудсанд байрлуулан сурталчилна.

ЗУРГАА.УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ

6.1.Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах ажилтныг томилно.

6.2.Хүүхэд хамгааллын талаар мэдээлэл түгээх, ажилтан, албан хаагчдыг эцэг эхийн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

6.3.Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.

6.4.Хүүхдэд ээлтэй байгууллага байх талаар хамт олонтойгоо нээлттэй ярилцаж, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой мэдээлэл, хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагад холбон зуучлах мэдээлэх арга хэмжээ авна.

6.5.Ажилтан, албан хаагчдад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, зөрэг хүмүүжлийн артын талаар болон холбогдох хууль эрхийн актуудын талаар мэдээлэл өгч, сургалт явуулна.

6.6.Хүүхэд үл хайхрагдах, эцэг эхийн халамж анхаарал дутах үндсэн шалтгааны нэг архины хамааралд орохоос сэргийлэхийн тулд архинаас хол, нийгмийн хариуцлагатай хамт олон байх хөдөлгөөн өрнүүлнэ.

ДОЛОО.ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ БАРИМТЛАХ

7.1.Нийт ажилтнууд болон шинээр ажилд орж байгаа хүмүүс хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурж гэрээ байгуулна. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн ажилтанд зөвлөх, зааж сургах, сахилгын арга хэмжээ авах, үүрэгт ажлаас нь өөрчлөх, түдгэлзүүлэх, чөлөөлөх эсвэл хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх заалтыг ажлын гэрээнд тусгана.

НАЙМ.ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

8.1.Байгууллагын үйл ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй аливаа эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, хор нөлөөг нь багасгахад байнга анхаарч ажиллана. Өөрийн үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг ханган аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллана.

8.2.Хэвлэл мэдээлэл, цахим орчинд авах арга хэмжээ:

Хүүхэд гэр бүлийн асуудлаар нэвтрүүлэг, сурвалжлаг, контент хийхэд оролцдог нийт ажилтнуудад НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцод заасан хүүхдийн хувийн мэдээлэл, нууцлалгаа хамгаалуулах эрхийг хүндэтгэх талаар болон тэдний ажлын улмаас хүүхдэд учирч болзошгүй эрсдэл, хохирлын талаар сургалт явуулах, хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангана.

8.3.Үзвэр үйлчилгээ, нийтийн тээврийн байгууллагаас авах арга хэмжээ:

Хүүхдийг хүндэтгэж, хүүхэдтэй зөв харьцах соёлыг ажилтнуудад хэвшүүлэх талаар байнга сургалт явуулах, мэдээлэл өгөх, шинээр ажилд хүн авах ярилцлагадаа хүүхэдтэй харьцах чадвар, соёлыг шалгуур үзүүлэлтийн нэг болгох, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийг доромжилсон гомдол, мэдээллийг хүлээн авах байгууллагын утас болон бусад холбогдох хэргийг үйлчилгээний газарт байрлуулах, мэдээллийн дагуу холбогдох хүнд ойлгуулах, анхааруулах болон бусад арга хэмжээг авч хэвших.

8.4.Хүүхдийг нийгмийн бүхий л орчинд хамгаалах иргэн, хуулийн этгээд анхаарах:

Худалдаа үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан, тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах бүх талын арга хэмжээг авах, зохион байгуулагч болон оролцогч талууд

ЕС.БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧ БОЛОН НИЙТ ГИШҮҮДИЙН

БАРИМТЛАХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

9.1.Байгууллагын нийт ажилтны хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн гол

зорилго нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад орших бөгөөд байгууллагын ажилтны зүгээс хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй, зохисгүй зан авир гаргахгүй байхад чиглэнэ.

9.2.Зөвшөөрөх:

- 1.Хүүхдэд дээрэнгүй хандахгүй байх;
- 2.Бүх хүүхдэд хүндэтгэлтэй хандах,
- 3.Харилцааны зөв үлгэр дуурайлал үзүүлэх;
- 4.Хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодын шийтгэл хэрэглэхгүй байх, эерэг хүмүүжлийн аргыг ашиглах;
- 5.Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
- 6.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг бусад зүйлсийг хэрэглэх нь хүүхдийг садар самуунд ашиглахыг дэмжиж байгаагийн илрэл болохыг ойлгож, ийм зүйлсээс татгалзах.
- 7.Хүүхдийн эрх зөрчигдөж байгаа талаар мэдсэн болон таамагласан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх.

9.3.Хориглох:

- 1.Хүүхдийг цохих, зодох, тусгаарлан хорих зэргээр бие махбодын хүчирхийлэлд оруулах;
- 2.Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, сэтгэл санааны дарамтад оруулах, нэр хоч өгөх;
- 3.Хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, уруу татах, биеийг үнэлүүлэх ажилд оролцуулах;
- 4.Хүүхдийг бэлгийн харьцаа хандлагаар өдсөн тоглоом тоглох, шалиг үг яриа ярих, бусдад тийм боломж олгох;
- 5.Хүүхдийн хөдөлмөрийг мөлжих;
- 6.Хууль бус эсвэл хүүхдэд аюултай үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг тоохгүй орхих
- 7.Хүүхдийн дэргэд хараал, бүдүүлэг үг хэрэглэх
- 8.Хүүхдэд буруу үлгэр дуурайл үзүүлэх
- 9.Хүүхдийг ямар нэг байдлаар нь ялгаварлан харьцах зэргийг хориглоно

--oOo--



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 2/08

Хархорин сум

Өмч хамгаалах байнгын зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын баталсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.1, 2.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Хууль эрхзүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн Нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга:	Нярав

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн актыг мөрдөж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай” Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.



403100015

C:\My Doc\Тушаал\ZDTG\



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 1/09

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, аймгийн Засаг даргын 2021 оны а/561 дүгээр захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн 2.1.1.2, 2.1.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалт болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын сургалтын төлбөрт зориулж 4,095,000 (дөрвөн сая ерэн таван мянга) төгрөг зарцуулж, задаргааг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын Тамгын газрын сургалт, дадлагын зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Х.ЛХАГВАДУЛАМ

403100917

Хархорин сумын Засаг даргын Тамгын
2026 оны 15 дугаар сарын 15-ны өдрийн
дүгээр тушаалын хавсралт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ БОЛОН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДСАН АЛБАН ХААГЧДЫН НЭРС,
СУРГАЛТЫН ТӨЛБӨР

№	Овог нэр	Албан тушаал	Сургалтын нэр	Төлбөр
1	Н.Нямдаваа	Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	1,000,000
2	С.Мөнхсоёл	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	945,000
3	Т.Бямбасүрэн	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	945,000
4	Э.Нарангэрэл	Соёл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	Төрийн албан хаагчиг чиглүүлэх богино хугацааны сургалт	200,000
5	А.Цэрэнчимэд	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	Төрийн албан хаагчиг чиглүүлэх богино хугацааны сургалт	200,000
6	Б.Сарангэрэл	Багийн Зохион байгуулагч	Төрийн албан хаагчиг чиглүүлэх богино хугацааны сургалт	200,000
7	С.Баасансүрэн	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах	605,000

--oOo--



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/10

Хархорин сум

**Ажлын хэсэг байгуулах
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Солонго (Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Д.Хишигсүрэн (3 дугаар багийн Зохион байгуулагч)
Э.Үүрцайх (Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Пүрэвсүрэн (1 дүгээр багийн Зохион байгуулагч)

Нарийн бичгийн дарга: Б.Сарангэрэл (2 дугаар багийн Зохион байгуулагч)

2.Тооллогыг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Солонго)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Х.ЛХАГВАДУЛАМ

403100010

C:\My Doc\Тушаал\ZDTG\



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 9/11

Хархорин сум

Байгууллагын эцэг, эхийн зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хуухдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Засаг даргын Тамгын газрын "Эцэг эхийн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
- 2.Зөвлөлөөс зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг эцэг эхийн зөвлөл (А.Цэрэнчимэд)-д даалгасугай.

ДАРГА Х.ГЯАГВАДУЛАМ



403100021
С:Мү Дос/Гушааг/ЗДТГ/



संयुक्त निदेश - १९८७

संयुक्त निदेश - १९८७

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश

संयुक्त निदेश